



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Булган сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/13/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг Даланзадгад сум 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533552 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Аудитор: Н.Хулан Утас: 70533552 Цахим хаяг: khulann@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Булган сумын 5-р цэцэрлэг нь “Орон нутгийн бодлого шийдвэрт уялдуулан, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, үлгэр, ардын аман зохиолоор дамжуулан хүүхэд бүрийн жүжиглэх, дүрд хувирах чадварыг хөгжүүлж, сургалтын арга зүйд шинэ дэвшилт гаргах, хүүхдийг хөгжих явцад тулгарч буй бэрхшээлийг судлан түүнийг арилгах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, харилцаа хандлага, үйлчилгээний чанар нэгдмэл санаагаараа манлайлагч хамт олон болно.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/төгрөгөөр/
Санхүүгийн байдлын тайлан		
	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,234,452.87
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	461,967,525.70
	Нийт хөрөнгийн дүн	<u>475,201,978.57</u>
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	475,201,978.57
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	280,174,509.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	265,149,066.23
	Үйл ажиллагааны үр дүн	15,025,442.77
	Үйл ажиллагааны бус үр дүн	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	15,025,442.77
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	460,175,966.58
	Тайлант оны үр дүн	15,025,442.77
	Эцсийн үлдэгдэл	475,201,409.35
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	187,768,150.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	187,768,150.00
	Үйл ажиллагааны ЦМГ	
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	177,211,553.63
	Урсгал зардал	177,211,553.63
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	177,211,553.63
	Улсын төсвөөс санхүүжих	153,712,300.37
	Орон нутгийн төсвөөс	23,499,253.26

Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

3	ТЭЗ										
	НИЙТ										

5.2 Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 143.3 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 акт, 35.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан 107.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

Зургаа. Аудитын санал дүгнэлт /баталгаажсан хувийг оруулах/



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: omnugovi@audit.gov.mn

**БУЛГАН СУМЫН 5-Р ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.ЭНХТУЯА ТАНАА**

2022.02.22 № 128

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Булган сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Эргэлтийн хөрөнгийг тулган баталгаажуулахад 12,931,107.0 төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, цэцэрлэгийн хүүхдийн хоолны нормыг 123,500.0 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол, УСНББОУС-12 Бараа материал, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

016020239

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Е.ЦЭРЭНБАЯР